



Батлав. Өвөрхангай аймаг
Нарийнтээл сумын
Засаг дарга  Б.Сугар

Батлав. Өвөрхангай аймаг
Нарийнтээл сумын
ИТХ-ын дарга  Ц.Ганхуяг

Батлав. Имперо майнинг
ХХК-н Гүйцэтгэх захирал
Б.Батцэцэг 

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ, УУРХАЙ АШИГЛАХТАЙ ХОЛБООТОЙ ДЭД БҮТЦИЙГ ХӨГЖҮҮЛЭХ АЖЛЫН БАЙР НЭМЭГДҮҮЛЭХ ТУХАЙ ГЭРЭЭ

2023 оны 05 дугаар сарын 24

№

23/01.

Цагаан-Овоо

Энэхүү гэрээг нэг талаас Өвөрхангай аймгийн Нарийнтээл сумын Засаг дарга Б.Сугар /цаашид А тал гэх/ нөгөө талаас Имперо майнинг ХХК /6613713 төлөөлж Гүйцэтгэх захирал Б.Батцэцэг/ цаашид Б тал гэх / нар Ашигт матмалын тухай хуулийн 42-р зүйлийн 1 дэхь хэсгийг үндэслэн дараах нөхцөлөөр харилцан тохиролцож 2023 оны 05-р сарын 24-ний өдөр байгуулав.

Нэг.Нийтлэг үндэслэл

- 1.1 Энэхүү гэрээ нь Өвөрхангай аймаг Нарийнтээл сумын нутагт Ашигт малтмалын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийн дагуу олгосон МУ-022144 тоот тусгай зөвшөөрөл эзэмшигчийн байгаль орчныг хамгаалах, уурхай ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх асуудлаар орон нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллахтай холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь тухайн зөвшөөрөл бүхий орших аймаг, сумын байгаль орчныг хамгаалах уурхай ашиглах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэх төсөл хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд сайн дурын үндсэн дээр энэхүү гэрээнд зааснаар дэмжлэг үзүүлнэ.
- 1.3 Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигчийн МУ-022144 тоот тусгай зөвшөөрлийг бүхэлд хамаарна.

Хоёр.Засаг даргын эрх, үүрэг

2.1 Энэхүү гэрээний хүрээнд сумын Засаг дарга дараах эрх үүргийг хэрэгжүүлэнэ.

2.1.1 Хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд ашигт малтмал эрэн хайх ашиглах үйл ажиллагааг тогтвортой хэвийн явуулах нөхцөлөөр тусгай зөвшөөрөл эзэмшигчийг хангах

2.1.2 Гэрээний хүрээнд хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл арга хэмжээний талаар орон нутгийн иргэдэд мэдээлэл өгөх

2.1.3 Энэхүү гэрээний хэрэгжилттэй холбоотой уулзалт хэлэлцүүлэг зохион байгуулж сум, багийн иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулна.

2.1.4 Тусгай зөвшөөрлийн эзэмшигчийн ажлын байртай холбоотой мэдээлэлийг иргэдэд хүргэх

2.1.5 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн Байгаль орчны менежементийн төлөвлөгөөнд хяналт тавих

2.1.6 Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн гаргасан хүсэлт шаардлагын хууль тогтоомжинд нийцүүлэн зохих хариуг өгөх

2.1.7 Үйл ажиллагаагаа эхэлсэн аж ахуй нэгжид сум орон нутаг, төрийн байгууллагын албан хаагчид иргэдээс хууль бус дарамт шахалт үзүүлэх асуудлыг таслан зогсоож буруутай этгээдэд арга хэмжээ авах

Гурав. Тусгай зөвшөөрөл эзэмшигчийн эрх, үүрэг

3.1 Энэхүү гэрээний хүрээнд тусгай зөвшөөрөл эзэмшигч дараах эрх үүргийг хэрэгжүүлэнэ.

3.1.1 Үйл ажиллагаагаа хэвийн тасралтгүй явуулахад орон нутгийн иргэд, хуулийн этгээдийн зүгээс хууль бусаар саад учруудсан тохиолдолд уг асуудлыг зохих журмын дагуу Засаг дарга, ИТХ-д тавьж шийдвэрлүүлэх

3.1.2 Орон нутгийн иргэдийн хөдөлмөр эрхлэлтийг дэмжиж тэднийг сургалтанд хамруулах талаар холбогдох албан тушаалтантай хамтран ажиллаж шаардлагатай ажлын байр болон түүнд тавих шаардлагыг ил тод нээлттэй хэлбэрээр явуулах

3.1.3 Хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний хүрээнд шаардлагатай ажлын байрны хөтөлбөр боловсруулах

3.1.4 Нийт ажиллах хүчний 40 хувь хүртэл орон нутгаас ажиллуулах

3.1.5 Бараа ажил үйлчилгээ худалдан авахдаа тухайн орон нутагт бүртгэлтэй татвар төлөгч иргэн хуулийн этгээдэд тэргүүн ээлжинд давуу эрх олгохыг эрмэлзэх

3.1.6 Байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын баталсан ажлын төлөвлөгөө хөтөлбөрийг биелүүлж ажиллах

3.1.7 Гамшигийн үед сайн дурын үндсэн дээр орон нутагт дэмжлэг туслалцаа үзүүлэх

3.1.8 Эрх бүхий албан тушаалтанаас тавьсан хууль ёсны шаардлагыг биелүүлж ажиллах

3.1.9 Уул урхай ил тод байдлыг бий болгож олборлосон баялаг татвар төлбөрөө тайлагнаж байх

3.1.10 Уурхай эрхлэхэд шаардагдах Ашигт малтмалын тухай хуульд заасан бичиг баримтын бүрдэлийг бүрэн хангасан үед ажлаа эхлүүлэх

3.1.11 Нийгмийн хариуцлагын хүрээнд сум, багийн өмнө тулгамдаж байгаа аливаа асуудлыг шийдвэрлэхэд дэмжлэг үзүүлэх талаар санал санаачлага гаргах

3.1.12 Ус ашигласаны төлбөрийг тоолуураар тооцон орон нутагт тушаана.

Дөрөв. Хамтын ажиллагааны хороо

4.1 Талуудын гэрээ байгуулах үйл явц болон гэрээний хэрэгжилтэд хяналт тавих ажлыг зохион байгуулах үүрэг бүхий хороо ЗДТГ болон тусай зөвшөөрөл эзэмшигч мөн орон нутгийн иргэдийн төлөөлөлийг оролцуулан байгуулж ажилуулж болно.

Тав. Гэрээний хэрэгжилт

5.1 Гэрээний ил тод байдлыг хангах зорилгоор улирал бүр хамтран гүйцэтгэсэн ажлыг дүгнэн баталгаажуулна.

5.2 Талууд гэрээний биелэлтийг жилийн эцэст дүгнэн дараа оны 2-р сарын 01-ний дотор сум багийн ИТХ-д хүргүүлнэ.

Зургаа. Гэрээний хариуцлага

6.1 Талууд гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ. Энэхүү гэрээ нь тусгай зөвшөөрөл эзэмшигч хууль тогтоомжоор хүлээсэн бусад үүргээс татгалзах үндэслэл болохгүй

6.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч гэрээ байгуулсныг Геологи уул уурхайн асуудал хариуцан төрийн захиргааны байгуулагад тогтоосон хугацаанд хүргүүлнэ.

Долоо. Гэрээ хүчин төгөлдөр болох

7.1 Талууд гарын үсэг зурсан өдрөөс хойш тухайн жилийг дуустал гэрээ хүчин төгөлдөр үйлчилнэ.

7.2 Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас гэрээг хугацаанаас өмнө дуусгавар болгож болно.

7.3 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно. гэрээнд оруулсан нэмэлт өөрчлөлт нь гэрээний нэгэн адил хүчинтэй байх бөгөөд түүний салшгүй хэсэг болно.

7.4 Гэрээг 2 хувь Монгол хэл дээр үйлдэнэ. Гэрээг зайлшгүй тохиолдолд англи хэл дээр үйлдэж болно.

Найм. Төсөл хөтөлбөр боловсруулах, хэрэгжүүлэх

8.1 Талууд сум, багийн иргэдийн санал хүсэлтэд суурилсан сумын ИТХ-р батлагдсан орон нутгийг хөгжүүлэх урт болон дунд хугацааны хөтөлбөрт хамтран ажиллана.

8.2 Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь 2023 онд төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин хүн амд нөлөөлөх нөлөөлөлийг бууруулах, дэд бүтцийг хөгжүүлэх, ажлын байр нэмэгдүүлэхэд дараах хандивыг үзүүлнэ.

№	Хийх ажлын нэр	Тоо хэмжээ	Мөнгөн дүн / төгрөгөөр/	Хугацаа	Хаана
1	Сумын төвийн худагт ус цэвэршүүлэгч,	1	25 000 000	2023.07.20-ны дотор	Сумын төвд

	Ухаалаг систем тавих				
2	Сумын төвийн хогийн цэгийн хогийг Булшлах цэгцлэх	1	3 000 000	2023.06.05-ны дотор	Сумын төвд
3	Баянтээг багийн төвийн Хогийн цэгийг хашаажуулах	1	10 000 000	2023.08.31-ны дотор	Баянтээг баг
4	Баянтээг багт болон Сумын төвд Хог преслэгч /20 тонн/	2	12 000 000	2023.07.20-ны дотор	Баянтээг баг
5	Мал угаалгын банн Баянтээг багт байгуулах	1	15 000 000	2023.09.30-ны дотор	Баянтээг баг
6	Усалгааны систем	1	40 000 000	2023.06.20-ны дотор	Аймгийн төвд
7	Ус нөөцлөх сав	5		2023.06.20-ны дотор	Аймгийн төвд
8	Бордоо	5 тонн		2023.06.20-ны дотор	Аймгийн төвд
9	Уян шланг /32 мм/			2023.06.20-ны дотор	Аймгийн төвд
	Нийт		105 000 000		

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

Өв аймаг Нарийнтээл сумын
 БО-ны Улсын Байцаагч
Цэрэндорж Төгс Г. Наранбаатар
 Утас: 89214788, 96900964

